



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A/43

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Архивын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын 2018 оны 23 дугаар хурлын тэмдэглэлийн 9 дүгээр хэсэг, ОХУ-ын нийгэм, улс төрийн түүхийн архиваас ирүүлсэн урилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Оросын Холбооны Улсын Москва хотноо 2019 оны 04 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд ОХУ-ын нийгэм, улс төрийн түүхийн архиваас зохион байгуулах “Түүхийн баримт бичиг, үндэсний ба олон улсын орчин үеийн болон өнөө цагийн археографийн, архивын, эх сурвалж судлалын бодит асуудлууд” сэдэвт 9 дүгээр бага хуралд Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын мэргэжилтэн Г.Баясгалан, Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивын архивч Ц.Эрдэнэбулган нарыг оролцуулсугай.

2. Албан томилолтын зардлын төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Албан томилолтод шаардагдах **7.149.320** (долоон сая нэг зуун дөчин есөн мянга гурван зуун хорин) төгрөгийг томилолтын зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Цэвэлмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажилласан дүнг ирснээс хойш ажлын 5 хоногт багтаан илтгэх хуудсаар танилцуулахыг Г.Баясгалан, Ц.Эрдэнэбулган нарт даалгасугай.

ДАРГА

С.ЭНХБААТАР



Tushaal
368110204

Архивын ерөнхий газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 14 өдрийн 4/43
тушаалын хавсралт

ОХУ-ын нийгэм, улс төрийн түүхийн архиваас зохион байгуулж байгаа «Түүхийн баримт бичиг, үндэсний ба олон улсын орчин үеийн болон өнөө цагийн археографийн, архивын, эх сурвалж судлалын бодит асуудлууд» сэдвийн хүрээнд залуу эрдэмтэн, судлаачдын дунд зохиогдож байгаа IX бага хуралд оролцох зардлын тооцоо

Д/д	Явах чиглэл	Унааны зардал				Унааны зардлын нийт дүн	Томилолтын зардал				
		км	Хүний тоо	Ирэх/буцах	Онгоцны билет		Ажиллах хоног	Хүний тоо	1 хүн	Дүн /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	3	4		5	6	7	8	9	10	11	12
1	УБ-МОСКВА-УБ		2		1,885,000	3,770,000	3	2	563,220	3,379,320	7,149,320
Дүн						3,770,000			563,220	3,379,320	7,149,320